



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 17

Арвайхээр

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл
ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "д", сумын ИТХурлын Төлөөлөгчдийн "Арвайхээр сумын Засаг даргын 2016-2020 оны Бүтээлч-Арвайхээр үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 2016 оны 2/01 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх "БҮТЭЭЛЧ АРВАЙХЭЭР" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг төсөвт байгууллагын удирдлагууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын нийт албан хаагчдад, хэрэгжилтийн явц үр дүнг тооцон биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /В.Шоовдор/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН